



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/375

Булган сум

**Буудлагын спортын тамирчин
Баттөгсийн Амин-Эрдэнэд дэмжлэг
үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд, залуучуудыг биеийн тамир, спортоор тогтмол хичээллэх нөхцөлийг бүрдүүлж, ур чадвар, авьяасыг хөгжүүлэх, олон улсын тэмцээнд оролцох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор буудлагын спортын өсвөрийн 1 дүгээр зэргийн тамирчин Баттөгсийн Амин-Эрдэнэд техник, хэрэглэгдэхүүний зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



05 Аймгийн Засаг даргын 2026 оны
#1376 дугаар сарын ...-ны/ний өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

УУЛЗАЛТ, СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Өглөөний цай	1	15	27,000	405,000
2	Өдрийн хоол	1	18	50,000	900,000
3	Оройн хоол	2	18	50,000	1,900,000
4	Нийт дүн				3,205,000

--o00o--